



УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1987 оны 9 сарын 22 өдөр

Дугаар 253

Улаанбаатар хот

Хотын барилга захиалагчийн
товчоонд мөрдөх цагналын
дүрэм батлах тухай

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

БНМАУ-ын Хөдөлмөр нийгэм хангамжийн улсын хороо, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөлийн 1982 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 340/194 дүгээр тогтоолыг үндэслэн боловсруулсан, тус товчоонд мөрдөх цагналын дүрмийг хавсралтын дагуу баталж 1987 оны 7 дугаар сарын I-ний өдрөөс эхлэн мөрдөхийг Барилга захиалагчийн товчоонд зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА *[Signature]* С.ЖУУХМАРТАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦИАГАТАЙ НАРИЙН
БҮЛЭГЧИЙН ДАРГА Д.АЛТИА

[Signature]



Улаанбаатар хотын АХХ-ын гүйцэтгэх
захиргааны 1987 оны дугаар сарын
ны өдрийн дугаар тогтоолын
хавсралт

ХОТЫН БАРИЛГА-ЗАХИАЛГАЙН ТОВЧООНД МӨРДӨХ ШАГНАЛЫН КУРАМ

НЭГ. Хяналтын инженер техникийн ажил- тан ажилчдын шагнал

Хариуцсан барилга байгууламж дээрээ техникийн хяналтыг тогт-
мол хийж нормативт хугацаанд нь буюу хугацааны нь өмнө, төсөвт
ертогт нь баргасан, чанарын сайнаас онц үнэлэлттэй ашиглалтад
өгөхөд идэвх зүтгэл гаргаж ажилласан хяналтын инженер техникийн
ажалтан ажилчдын материаллаг сонирхлыг өргүүлэхэд журмын зорилго
оршино.

1. Улсын онц чухал барилга объектыг төлөвлөгөөт хугацаанд ча-
нарын сайнаас онц үнэлэлттэй ашиглалтад оруулсан хяналтын инженер,
техникчийг доорх журмаар шагнана.

а/ төлөвлөгөөт хугацаанд нь ашиглалтад оруулбал сарын палин-
гийн 40-60 хувь;

б/ төлөвлөгөөт хугацааг нэгээс гурван сараар хэмнэвэл сарын
палингийн 60-80 хувь;

в/ төлөвлөгөөт хугацааг 5 сараас дээш хэмнэвэл сарын палин-
гийн 80-100 хувь хүртэл тус тус олгоно.

2. Төлөвлөгөөт объектыг хугацаанд нь буюу хугацаанаас нь өмнө
сайнаас онц үнэлэлттэй ашиглалтад оруулбал доорх журмаар шагнал
олгоно.

а/ төлөвлөгөөт хугацаанд нь ашиглалтад оруулбал сарын палин-
гийн 20-40 хувь,

б/ төлөвлөгөөт хугацааг 1-ээс 3-н сараар хэмнэвэл сарын палин-
гийн 40-60 хувь,

в/ гурван сараас дээш хугацаагаар хэмнэвэл 60-80 %.

НӨӨР. Товчооны удирдах ажилтанд олгох шагнал

1. Улсын онц чухал объектыг хугацаанд нь буюу хугацаанаас нь
өмнө ашиглалтад оруулбал товчооны дарга, ахлах инженерийг сарын
палингийн 40-60 хувь хүртэл.

2.

2.Улирлын ашиглалтад оруулах барилгын төлөвлөгөөг биелүүлвэл товчооны дарга, ахлах инженерийг сарын цалингийн 40-60 хувь.

3.Хагас, бүтэн жилийн ашиглалтад оруулах барилгын төлөвлөгөөг биелүүлвэл сарын цалингийн 30-100 хувь.

4.Хагас жил, жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө биелэвэл ахлах ня-бо, туслах ня-бог сарын цалингийн 30-100 хувь хүртэл тус тус олгоно.

IV. А. Магналын эх үүсвэр шагнал олгох журам

1.Товчооны удирдлага, хяналтын ИИА-д олгох шагналыг уг барилгын шагналын захиалагчид ноогдох хувь, техник хяналтын зардлын хэмнэлтээс гаргана.

2.Зураг төсөл, захиалагч байгууллагын удирдах инженер техникийн ажилтан албан хаагчдад барилга объектиг хугацаанд нь чанартай барьж ашиглалтад оруулсан үед олгох шагналыг тухайн ажилтны ажилласан хугацаа, барилга баригдах хугацаанд ажилд оролцсон идэвх, санаачилга, бүтээлийг харгалзан байгууллагын захиргааны тушаалаар олгоно. Харин зураг төслөөр саатуулсан буюу зураг төсөвгүй барилга объект баригдсан захиалагч байгууллагын удирдах, инженер техникийн ажилтан, албан хаагчдад шагнал олгохгүй.

3.Товчооны дарга, ахлах инженер, ахлах ня-бо, туслах ня-бо-д олгох шагналыг Их барилгын хэлтсийн тушаалаар олгоно.

4.Хяналтын инженер техникчдэд олгох шагналыг товчооны даргын тушаалаар олгоно.

5.Товчооны удирдлага, инженер техникийн ажилчдын шагналын жилийн дээд хэмжээ нь 3 сарын цалингийн амьдралд хөтөрч болохгүй.

6.Товчооны удирдах хүмүүст олгох шагналыг холбогдох асуудлуудыг үндэслэн хасах, хувь бууруулах асуудлыг салбар харлуусан хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны орлогч дарга, Их барилгын хэлтэс шийдвэрлэнэ.

7.Инженер техникийн ажилчдад олгох шагналыг хасах, хувь бууруулах асуудлыг холбогдох асуудлуудыг үндэслэн Их барилгын хэлтсийн дарга, товчооны дарга шийдвэрлэнэ.